

Аж ахуй нэгжүүдийн анхааралд.

Аж ахуйн нэгж, байгууллагын тооллого явуулах
тухай.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 315 дугаар тогтоол, Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01/867 тоот албан бичиг, Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 04/2639 тоот албан бичгийн дагуу 11 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 01-ны хооронд аж ахуйн нэгжийн ээлжит тооллогыг улсын хэмжээнд зохион байгуулах шийдвэрийн дагуу Үндэсний геологийн алба нь харъяа, уул уурхай, хүнд үйлдвэрийн чиглэлээр тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдийг тооллогод хамрагдахыг мэдэгдэж байна.

Аж ахуйн нэгж байгууллагын тооллогын асуулга маягыг toollogo.1212.mn сайт дээр зааврын дагуу цахимаар бөглөнө үү.

Үндэсний геологийн алба



ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ
ДАРГА О.ЧУЛУУН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,
<http://www.mnh.gov.mn>

2021.11.01 № 04/2639
танай _____-ны № _____-т

Чиглэл хүргүүлэх тухай


Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 315 дугаар тогтоолоор байгуулагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогыг нэгдсэн удирдамжаар ханган ажиллах комисс" анхдугаар хуралдаанаа зохион байгуулж, зарим шийдвэрүүдийг гаргажээ.

Гаргасан шийдвэрийн дагуу өөрийн байгууллага болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, салбар, төлөөлөгчийн газруудыг аж ахуйн нэгжийн тооллогод бүрэн хамруулах удирдамж, зөвлөмжөөр ханган ажиллана уу.

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн "Комиссын шийдвэр хүргүүлж, тооллогод ажилтныг томилон ажиллуулах тухай" 01/867 дугаар албан бичиг, тооллого хийх зааврыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 10 хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА Т.БАТБАЯР



00 08 2269



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44,
Засгийн газрын III байр, Утас: 32 14 33
Факс: (976-11) 32 14 33, И-мэйл: international@nso.mn,
Вэбсайт: www.nso.mn

2021. 10. 26 № 01/2021
танай _____-ны № _____-т

Комиссын шийдвэр хүргүүлж,
тооллогод ажилтныг томилон
ажиллуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 315 дугаар тогтоолоор байгуулагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогыг нэгдсэн удирдамжаар ханган ажиллах комисс"-ын анхдугаар хурал 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдлаа.

Комиссын анхдугаар хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу танай салбарын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагын тооллогыг хариуцан зохион байгуулах, нууцын асуудал хариуцсан 2-3 ажилтанг томилж, Үндэсний статистикийн хорооноос зохион байгуулах тооллогын цахим сургалтад оролцуулж, тооллогын ажлыг чанартай зохион байгуулахыг хүсье.

Жич: Албан тушаалтны нэр, албан тушаал, цахим шуудан, утасны дугаарыг комиссын нарийн бичгийн дарга Э.Эрдэнэсан (erdenesan@nso.mn; 99132929)-д ирүүлнэ үү.

Хавсралт: 2 хуудастай.

ХҮНДЭТГЭСЭН,

АЖ АХУЙН НЭГЖИЙН 2021 ОНЫ ЭЭЛЖИГ ТООЛЛОГЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ КОМИССЫН ОРЛОГ ДАРГА ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА

Б.БАТДАВАА



Комиссариат
Огноо зовоомин
Залуу орго хэмээх өвөр
М.Н. 1100/2. 2021

142001100777